

ХҮРЭЭЛЭНГИЙН 25 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ- НИЙ БАГА ХУРАЛ

Энэ 6-р сарын 28-нд ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн Улсын нийтийн номын сангийн хурлын танхимд хүрээлэн байгуулагдсаны 25 жилийн ойд зориулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.

ДДОУС-ын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор Х.Дашдондов эрдэм шинжилгээний бага хурлыг нээж, хүрээлэнгийн захирал, түүхийн ухааны дэд доктор Ц. Батбаяр анх хүрээлэн байгуулагдсан түүх, тус хүрээлэнгээс хийж гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний ажил, одоо явуулж байгаа эрдэм шинжилгээний ажлыг нэгтгэн дүгнэж «Олон улс судлалын өнгөрсөн, одоо, ирээдүй» гэсэн илтгэл тавив.

Хуралд ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Д. Баатар, ШУА-ийн нийгмийн ухааны салбарын дарга, академич, профессор С.Норовсамбуу нар болон ШУА-ийн нийгмийн ухааны хүрээлэнгүүдийн захирал, эрдэм шинжилгээний ажилтнууд, тус хүрээлэнг байгуулагдах үеэс эхлэн ажиллаж байсан эрдэм шинжилгээний ахмад ажилтнууд Ц. Хандсүрэн, Э. Пунцаг, Б. Саялхам, эрдэмтэн, зохиолч Д. Маам нарын зэрэг олон хүмүүс уригдан оролцлоо.

Бага хуралд ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Д. Баатар баяр хүргэж, тус хүрээлэнгийн эрдэмтэд, нийт ажилтнуудад эрдэм, оюуны бүтээлдээ их амжилт олохыг хүсэн ерөөгөөд академич, доктор, профессор Н. Ишжамц, дэд доктор Л.Жамсран, дэд доктор А. Дамдинсүрэн, дэд доктор М. Хурметхан, дэд доктор Ц.Батбаяр, эрдэм шинжилгээний ажилтан М. Нарантуяа нарын зэрэг хүмүүст ШУА-иас шагнал гардуулав.

Тус эрдэм шинжилгээний бага хуралд уригдан оролцсон Зүүн Хойд Ази судлалын төвийн захирал, доктор профессор Ч. Далай баяр хүргэж, хүрээлэн байгуулагдах үед тус хүрээлэнд ажиллаж байсан сэтгэгдлээ ярьж, хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, профессор Д. Ёндон, Түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд доктор Б.Дорж, Философийн хүрээлэнгийн захирал, дэд доктор С. Лодой нар хүрээлэнгийн хамт олныг төлөөлөн баяр хүргэж, бэлэг дурсгалын зүйл гардууллаа.

«Орчин үе, олон улс судлал», «Дорно дахины түүх, соёл судлал» сэдвээр тус бага хурал дээр хүрээлэнгийн зарим нэрт эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудаас эрдэм, судалгааны чиглэл болон одоо явуулж байгаа ажлыг нэгтгэн дүгнэж, задлан шинжилсэн «Монгол улсын бүрэн эрх, тусгаар тогтнолыг олон улсын эрх зүйн үүднээс хүлээн зөвшөөрснийг судалсан дүнгээс» (илтгэгч нь дэд доктор Х.Хашбат), «Зүүн Азийн орнуудын хөгжлийн туршлагын нийтлэг ба онцлог-Монгол» (д/п Х.Дашдондов), «Тайландын төрөөс эдийн засгийг зохицуулан хөгжүүлсэн нь» (ЭША. Д. Батсайхан), «Монголын гадаад харилцааны түүхэн уламжлал» (академич Н. Ишжамц), «Монгол Хятадын цагаагчин гахай жилийн хувьсгалын нийтлэг ба ялгаатай талууд (д/д. Л.Жамсран), «Монгол-Төвдийн харилцааны түүхээс, ХШ—XIV зуун». (д/д. А. Дамдинсүрэн), «БНХАУ дахь Монгол үндэстний байршилт»

(ЭША. Ч.Эрдэнэбаяр) зэрэг эрдэм шинжилгээний сонирхолтой илтгэл хэлэлцэж, сонирхсон сэдвээр эрдэмтэд санал, онолоо солилцов.

Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өнгөрсөн хугацаанд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудаас бичиж нийтэлж байсан бүтээлийн жагсаалтыг «Хэвлэгдсэн бүтээлийн хэлхээс» (1968—1993 он) нэртэйгээр жижиг товхимол болгон хэвлэн гаргалаа.

Мөн «Арга билэг» сонины нэг дугаарыг хүрээлэнгийн ойд зориулан гаргаж, хүрээлэнгийн түүх, ажил үйлс, тус хүрээлэнгийн ахмад ажилтнуудын дурсамж, хүрээлэнгийн бүтээлийн дээж, судалгаа шинжилгээний ажлын чиглэл, зорилтуудаас гадна хүрээлэнгээс эрхлэн гаргадаг олон улс судлалын анхны «Дорно-Өрнө» сэтгүүлийн 15 жилийн ой давхцаж байгаатай холбогдсон дурсамж өгүүллийг нийтэлжээ.

МАНАЙ ЛАВЛАХ

1993 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ (эхний хагас жилд)

1993.01.07 Монгол улс, Бүгд найрамдах Словак Улсын хооронд дипломат харилцаа тогтоов.

1993.01.09 Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар ажлын түр айлчлал хийхээр Улаанбаатарт хүрэлцэн ирсэн Буриад Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга В. Б. Саганов хоёр орны эдийн засаг, худалдаа боловсрол, шинжлэх ухаан, соёл урлагийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хоёр талын хилийн боомт болох Хиагт, Алтанбулагийн асуудлаар Ерөнхий сайд П.Жасрайтай санал солилцов.

1993.01.12. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй Улсын Их Хурлын төлөөлөгчид БНФУ-д албан ёсны найрсаг айлчлал хийж Францын албаны хүмүүстэй уулзаж, хоёр орны харилцааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон байна.

Мөн ХБНГУ-д албан ёсны айлчлал хийж ХБНГУ-ын Бранденбург муж улсаар зочилж тус муж улсын ган цувималын үйлдвэртэй танилцаж, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлд шилжих явцад учирч буй хүндрэл бэрхшээл, өмч хувьчлалын явцын талаар санал солилцсон байна.

Мөн Европарламентэд зочлон ерөнхийлөгч Е. Кленш, Европарламентын гадаад асуудал, аюулгүй байдлын байнгын хорооны дарга болон зарим гишүүдтэй уулзаж бүгд хуралдаанд нь орж сонирхсон байна.

1993.01.14, 15 Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн Парис хотноо болсон «Химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх, түүнийг устгах тухай» конвенцид гарын үсэг зурж мөн Итали улсад зочлон тус улсын Гадаад хэргийн сайд Эмилио Коломботой уулзаж хоёр талын харилцааны асуудлаар санал солилцож,